

**Монголбанканд
Голомт банкны ТУЗ-ийн хараат бус гишүүний 2023 оны II улирлын тайлан**

Хараат бус гишүүн James B. Dwyer III

Миний бие James B. Dwyer III (Жеймс Б.Двайер III) нь 2018 оны 3-р сард Голомт банкны (“Голомт” буюу “Банк”) Төлөөлөн удирдах зөвлөлийн (“ТУЗ”) хараат бус гишүүнээр сонгогдсон.

Би 2018 оны 3-р сараас 2021 оны 1-р сар хүртэл бүх ТУЗ-ийн хурал болон Банкны Хорооны хурлуудад биечлэн, 2021 оны 2-р сараас хойшхи хурлуудад цахим хэлбэрээр оролцсон болно.

Он сар өдөр	Хурал	Хэлэлцсэн асуудал	Шийдвэр	Санал
05.04.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	Төв оффисийн барилга захиалан бариулах тухай	Голомт банкны Төв оффисийн барилгын ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулахыг Голомт банканд зөвшөөрсөн.	Дэмжсэн
12.05.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	ТУЗ-ийн даргыг сонгох тухай	Голомт банкны ТУЗ-ийн даргаар Чүлтэм овогтой Мөнхцэцэгийг сонгосон.	Дэмжсэн
12.05.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	ТУЗ-ийн хорооны гишүүнчлэл: Аудитын хороо	Аудитын хорооны даргаар Ноён Жэймс Б.Двайер сонгогдсон. Хорооны гишүүдээр Ноён Антонио Л.Абэлло, Ноён Александр Пикер, Хатагтай Ч.Мөнхцэцэг, Ноён Д.Мөнхтөр нар сонгогдсон.	Дэмжсэн
		ТУЗ-ийн хорооны гишүүнчлэл: Эрсдэлийн удирдлагын хороо	Эрсдэлийн удирдлагын хорооны даргаар Ноён Жэймс Б.Двайер сонгогдсон. Ноён Антонио Л.Абэлло, Ноён Александр Пикер, Хатагтай Ч.Мөнхцэцэг, Ноён Ж.Үнэнбат нар сонгогдсон.	Дэмжсэн
		ТУЗ-ийн хорооны гишүүнчлэл: Нэр дэвшүүлэх хороо	Засаглал, ёс зүй, цалин урамшуулал, нэр дэвшүүлэх даргаар Ноён Александр Пикер сонгогдсон. Хорооны гишүүдээр Ноён Роберт В.Ван Свите болон Хатагтай Ч.Мөнхцэцэг нар сонгогдсон.	Дэмжсэн

		ТУЗ-ийн хорооны гишүүнчлэл: Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хороо	Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хорооны даргаар Ноён Антонио Л.Абэлло сонгогдсон. Хорооны гишүүдээр Ноён Жэймс Б.Двайер болон Хатагтай Ч.Мөнхцэцэг нар сонгогдсон.	Дэмжсэн
12.05.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хорооны тухай	ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, ёс зүй, цалин урамшуулал, нэр дэвшүүлэх үйл ажиллагаатай холбоотой хэсгийг салгаж Нэр дэвшүүлэх хороог шинээр байгуулсантай холбоотойгоор Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хороог өөрчлөн байгуулсан.	Дэмжсэн
19.05.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийн урамшууллын тухай	Гүйцэтгэх захирлын 4 жилийн контрактын ажлын гүйцэтгэлийг дүгнэсний үндсэн дээр урамшуулал олгох болсон.	Дэмжсэн
19.05.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	Гүйцэтгэх захирлын гэрээг сунгах тухай	Голомт банкны Гүйцэтгэх захирал Като овогтой Норихико-тай дахин нэг жилийн хугацаагаар контрактын гэрээг сунгасан.	Дэмжсэн
23.06.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	Голомт банкны "Тогтворжуулах төлөвлөгөө-2023" батлах тухай	Голомт банкны "Тогтворжуулах төлөвлөгөө-2023"-г баталсан.	Дэмжсэн
23.06.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	Голомт банкны бүтэц зохион байгуулалтыг өөрчлөн батлах тухай	Голомт банкны бүтэц зохион байгуулалтыг өөрчлөлтийг баталсан.	Дэмжсэн
23.02.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	Аудит хариуцсан захирлыг ажлаас чөлөөлөх тухай	Аудит хариуцсан захирал Амарзаяагийн Одонбаатар нь Гүйцэтгэх захирлын орлогчийн албан тушаалд томилогдсон тул Аудит хариуцсан Захирлын үүрэгт ажлаас чөлөөлсөн.	Дэмжсэн
23.06.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит/	Голомт банкны Зээлийн хорооны дүрэм болон Эрх бүхий этгээдийн зээл шийдвэрлэх	Голомт банкны Зээлийн хорооны дүрэм болон Эрх бүхий этгээдийн зээл шийдвэрлэх матрицийг өөрчлөн баталсан.	Дэмжсэн

		матрицийг өөрчлөн батлах тухай		
--	--	-----------------------------------	--	--

Аудитын хорооны гишүүний хувьд дараах байдлаар оролцсон. Үүнд:

Аудитын хороо нь 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдөр нэг удаа хуралдаж нийт 8 асуудал хэлэлцсэн.

Он, сар, өдөр	Хэлэлцсэн асуудал	Санал
23.06.2023	Санхүүгийн үр дүн (2023 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар, 2023 оны эхний хагас жилийн байдлаарх төсөөлөл)	Хэлэлцсэн
	Хөндлөгийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн талаар	Хэлэлцсэн
	Тогтворжуулах төлөвлөгөө 2023	Хэлэлцэж, баталсан
	Байгууллагын банкны үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан	Хэлэлцсэн
	Мэдээллийн системийн patch удирдлагын аудитын тайлан	Хэлэлцсэн
	ДАГ-ын Ерөнхий аудитын хэлтсийн захирлыг томилох санал	Хэлэлцэж, дэмжсэн
	Дотоод аудитын үйл ажиллагааны (ДАГ, ДАА) 2023 оны I улирлын ажлын тайлан, зардлын гүйцэтгэл, II-IV улирлын төлөвлөгөө	Хэлэлцэж, баталсан
	ДАГ-ын хэлтсийн захирлыг томилох санал	Хэлэлцэж, дэмжсэн

Хараат бус гишүүний хувьд дараах зүйлсийг онцолж хэлсэн:

- Голомт банкны 2023 оны 5 сарын санхүүгийн үх дүнг хянаж, Чанаргүй зээлийн хувь өсөж байгаа шалтгааны талаар асууж, хариултаа авсан.

- PwC-с өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хянаж, эдгээр зөвлөмжүүдийг цаг хугацаанд, чанартай биелүүлэхийг сануулсан.

- Монголбанканд хүргүүлэх Тогтворжуулах төлөвлөгөөний шинэчлэлтийг хянасан.

- Дотоод аудитын газраас (ДАГ)-аас танилцуулсан аудитын тайлангуудтай дэлгэрэнгүй танилцаж, хянасан.

- Мэдээллийн системийн patch удирдлага сул байснаар ямар эрсдэл учирч болох талаар асуулт асууж, хариулт авсан.

- Дотоод аудитын үйл ажиллагаа (ДАҮА)-ны үйл ажиллагааны тайлан, зардлын гүйцэтгэл, 2023 оны 3, 4-р улирлын ажлын төлөвлөгөөтэй танилцсан ба 2023 оны 3, 4-р улирлын төлөвлөгөөг баталсан.

- А.Туяаг Дотоод аудитын газрын захирал, Б.Хишигжаргалыг ДАГ-Ерөнхий аудитын захирлаар томилох саналтай танилцаж, хянасан. CV, ололт, амжилт, банканд оруулсан хувь нэмэртэй танилцаж, саналыг дэмжсэн.

Эрсдэлийн удирдлагын хорооны даргын хувьд дараах байдлаар оролцсон. Үүнд:

Тус улиралд Эрсдэлийн удирдлагын хороо нь 9 удаа хуралдаж, нийт 36 асуудлыг дараах өдрүүдийн хурлаар хэлэлцсэн.

- 2023.04.05
- 2023.04.18
- 2023.04.20
- 2023.04.27
- 2023.05.21
- 2023.05.23
- 2023.05.31
- 2023.06.20
- 2023.06.26

Санхүүжилтийг батлахад нарийвчлан хянаж, санал хураалтыг цахимаар авдаг. Асуудлуудын ихэнх нь 20.0 тэрбум төгрөг ба түүнээс дээш зээлийн өрийн үлдэгдэлтэй аж ахуйн нэгжийн зээлийн өрийн үлдэгдэлтэй холбоотой Зээлийн хорооны шийдвэрийг хянан шалгах талаар байв.

Чухал хэлцэл:

Тус тайлангийн хугацаанд хийгдсэн гүйлгээнүүдийн бүх холбогдох мэдээллийг хүлээн авч асуудлуудад дэмжсэн санал өгсөн.

ТУЗ-ийн гишүүний хувьд би дараахь зүйлийг онцлохыг хүсэж байна.

- Миний мэдэж байгаагаар Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагын шийдвэрүүд нь зөвхөн банкны эрх ашгийн төлөө, өөр бусад ашиг сонирхолгүйгээр гардаг гэдгийг баталж байна.

- ТУЗ-ийн үйл ажиллагаа нь бодлого боловсруулагчдаас гаргасан хууль тогтоомжийн дагуу явагддаг.

- ТУЗ-өөс засч сайжруулах боломжтой асуудлыг олж харсан тохиолдолд бид ТУЗ-ийн түвшинд хэлэлцүүлж, үйл ажиллагааг сайжруулах чиглэл өгч, эргэн мэдээлэх хугацаа өгсөн. Гүйцэтгэх удирдлагын баг эдгээр хүсэлтийг хүлээн авч, шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь авч ажиллаж байна.

-Би тайлант хугацаанд тус банкны ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд банкинд сөргөөр нөлөөлөх ямар нэгэн буруутай үйлдлийг илрүүлээгүй. Тиймээс би ямар нэгэн тодорхой асуудлаар ээлжит бус хурал хуралдуулах хүсэлт гаргаагүй.

- ТУЗ болон Удирдлагын баг нь гаргасан шийдвэр, үндэслэлийн талаар ил тод байж, цаг тухайд нь ил тод мэдээлдэг.

- ТУЗ-өөс тайлант хугацаанд гаргасан бүх шийдвэрийг санал хураалтад миний зүгээс маш сайн судалж, дэмжсэн болохыг үүгээр баталж байна.

- Надад асуулт эсвэл нэмэлт тодруулга авах шаардлага үүссэн тохиолдолд ТУЗ болон Удирдлагын багийн гишүүд зохих мэдээллийг өгч хамтарч ажилладаг.

- 2022 оны 11-р сард амжилттай IPO хийсний дараа Банкны удирдлага 2022 он болон 2023 оны эхний 6 сарын хугацаанд Үйл ажиллагааны ашгаа амжилттай бүрдүүлж чадсан. Банк нь Үйл ажиллагааны ашгаа дээд амжилт тогтоосон хэмжээнд нэмэгдүүлсээр байна. Гадаад эх үүсвэрийн хүртээмж хангалттай хэмжээнд байна.

- IPO амжилттай болсонтой холбогдуулан банкны олон нийттэй харилцах харилцааг ихээхэн онцолж байсан. Голомт банкиг “The Banker” сэтгүүлээс 2022 оны “Монголын шилдэг банк”-аар шалгаруулсан нь ч мөн адил энэхүү олон нийттэй харилцах ажиллагааны хүчин чармайлтын илэрхийлэл байлаа. Банкны "Сайн сайхныг санхүүжүүлнэ" хэмээх уриа, Байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) үйл ажиллагааг дэмжих, дижитал эрин дэх бүтээгдэхүүн, үйлчилгээнд анхаарлаа хандуулж урамшууллаа.

- Банкны бизнес төлөвлөлт, төсөвлөлт нь мөн үлгэр жишээ болсон. Шаардлагатай өөрчлөлтүүдийг цаг тухайд нь хийсэн. Төлөвлөгөөний зөрүүг хянаж, стратегид тухай бүрт нь өөрчлөлт оруулдаг. Сайн стратегийг тодорхойлохдоо бусад 4 том банктай харьцуулсан харьцуулалтыг тогтмол тэмдэглэдэг.

- ТУЗ, Хорооны хуралд удирдлагын баг болон захирлууд хамтран оролцож, нээлттэй хэлэлцүүлэг явуулдаг. ТУЗ-ийн гишүүд удирдлагын бодлого, үр дүнг чөлөөтэй асууж болно. Шаардлагатай бол эерэг шүүмжлэл хийх боломжтой.

- ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ болон хорооны хуралдааны өмнө ТУЗ-ийн гишүүдэд гишүүдэд зориулсан дэлгэрэнгүй мэдээллийг бэлтгэхэд хяналт тавьдаг. Захирлууд маш сайн мэдээлэлтэй бөгөөд уулзалтад үр дүнтэй хувь нэмэр оруулж чадна.

- Банкны бүтэц зохион байгуулалт тасралтгүй сайжирч, нэлээд үр дүнтэй ажиллаж байна.

- Банк 2022 оны санхүүгийн тайландаа PricewaterhouseCoopers (PwC)-аас шаардлага хангаагүй дүгнэлтийг хүлээн авсан. PwC мөн дотоод хяналтыг үргэлжлүүлэн хийсээр байна.

Хүндэтгэсэн,

James B. Dwyer III
Хараат бус гишүүн

Монголбанканд

Голомт банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүний 2023 оны II улирлын тайлан

бичсэн Александр Пикер

Александр Пикер, миний бие 2021 оны 12 сарын 23-нд Голомт банк (цаашид “банк” гэх)-ны Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн Хараат бус гишүүнээр сонгогдсон.

Миний бие 2023 оны 2 дугаар хагаст бүх ТУЗ-ийн болон гишүүн болох хороодын хуралд цахим системээр оролцсон байна.

Тус хугацаанд дараах ажлуудыг хийсэн. Үүнд:

- Холбогдох этгээдийн гүйлгээг хянах, ялангуяа ашиг сонирхлын зөрчлийг ажиглах – илрээгүй.
- Дотоод аудитын төлөвлөгөө, тайлан болон төлөвлөгөөний гүйцэтгэлийг дагаж хянах.
- Зээлийн хүсэлтийг шалгах
- Засаглал, ёс зүй, цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хорооны даргаар ажиллах.

Он сар өдөр	Уулзалт	Хэлэлцсэн асуудал	Шийдвэр	Санал
05.04.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	Төв оффисийн барилга захиалан бариулах тухай	Голомт банкны Төв оффисийн барилгын ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулахыг Голомт банканд зөвшөөрсөн.	Дэмжсэн
12.05.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	ТУЗ-ийн даргыг сонгох тухай	Голомт банкны ТУЗ-ийн даргаар Чүлтэм овогтой Мөнхцэцэгийг сонгосон.	Дэмжсэн
12.05.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	ТУЗ-ийн хорооны гишүүнчлэл: Аудитын хороо	Аудитын хорооны даргаар Ноён Жэймс Б.Двайер сонгогдсон. Хорооны гишүүдээр Ноён Антонио Л.Абэлло, Ноён Александр Пикер, Хатагтай Ч.Мөнхцэцэг, Ноён Д.Мөнхтөр нар сонгогдсон.	Дэмжсэн
		ТУЗ-ийн хорооны гишүүнчлэл: Эрсдэлийн удирдлагын хороо	Эрсдэлийн удирдлагын хорооны даргаар Ноён Жэймс Б.Двайер сонгогдсон. Ноён Антонио Л.Абэлло, Ноён Александр Пикер, Хатагтай Ч.Мөнхцэцэг, Ноён Ж.Үнэнбат нар сонгогдсон.	Дэмжсэн
		ТУЗ-ийн хорооны гишүүнчлэл: Нэр дэвшүүлэх хороо	Засаглал, ёс зүй, цалин урамшуулал, нэр дэвшүүлэх даргаар Ноён	Дэмжсэн

			Александр Пикер сонгогдсон. Хорооны гишүүдээр Ноён Роберт В.Ван Свите болон Хатагтай Ч.Мөнхцэцэг нар сонгогдсон.	
		ТУЗ-ийн хорооны гишүүнчлэл: Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хороо	Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хорооны даргаар Ноён Антонио Л.Абэлло сонгогдсон. Хорооны гишүүдээр Ноён Жэймс Б.Двайер болон Хатагтай Ч.Мөнхцэцэг нар сонгогдсон.	Дэмжсэн
12.05.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хорооны тухай	ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, ёс зүй, цалин урамшуулал, нэр дэвшүүлэх үйл ажиллагаатай холбоотой хэсгийг салгаж Нэр дэвшүүлэх хороог шинээр байгуулсантай холбоотойгоор Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хороог өөрчлөн байгуулсан.	Дэмжсэн
19.05.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийн урамшууллын тухай	Гүйцэтгэх захирлын 4 жилийн контрактын ажлын гүйцэтгэлийг дүгнэсний үндсэн дээр урамшуулал олгох болсон.	Дэмжсэн
19.05.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	Гүйцэтгэх захирлын гэрээг сунгах тухай	Голомт банкны Гүйцэтгэх захирал Като овогтой Норихико-тай дахин нэг жилийн хугацаагаар контрактын гэрээг сунгасан.	Дэмжсэн
23.06.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	Голомт банкны “Тогтворжуулах төлөвлөгөө-2023” батлах тухай	Голомт банкны “Тогтворжуулах төлөвлөгөө-2023”-г баталсан.	Дэмжсэн
23.06.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	Голомт банкны бүтэц зохион байгуулалтыг өөрчлөн батлах тухай	Голомт банкны бүтэц зохион байгуулалтыг өөрчлөлтийг баталсан.	Дэмжсэн
23.02.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	Аудит хариуцсан захирлыг ажлаас чөлөөлөх тухай	Аудит хариуцсан захирал Амарзаяагийг Одонбаатар нь Гүйцэтгэх захирлын орлогчийн албан тушаалд томилогдсон тул Аудит	Дэмжсэн

			хариуцсан Захирлын үүрэгт ажлаас чөлөөлсөн.	
23.06.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит/	Голомт банкны Зээлийн хорооны дүрэм болон Эрх бүхий этгээдийн зээл шийдвэрлэх матрицийг өөрчлөн батлах тухай	Голомт банкны Зээлийн хорооны дүрэм болон Эрх бүхий этгээдийн зээл шийдвэрлэх матрицийг өөрчлөн баталсан.	Дэмжсэн

Аудитын хорооны гишүүний хувьд дараах байдлаар оролцсон. Үүнд:

Аудитын хороо нь 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдөр нэг удаа хуралдаж нийт 8 асуудал хэлэлцсэн.

Он, сар, өдөр	Хэлэлцсэн асуудал	Санал
23.06.2023	Санхүүгийн үр дүн (2023 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар, 2023 оны эхний хагас жилийн байдлаарх төсөөлөл)	Хэлэлцсэн
	Хөндлөгийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн талаар	Хэлэлцсэн
	Тогтворжуулах төлөвлөгөө 2023	Хэлэлцэж, баталсан
	Байгууллагын банкны үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан	Хэлэлцсэн
	Мэдээллийн системийн patch удирдлагын аудитын тайлан	Хэлэлцсэн
	ДАГ-ын Ерөнхий аудитын хэлтсийн захирлыг томилох санал	Хэлэлцэж, дэмжсэн
	Дотоод аудитын үйл ажиллагааны (ДАГ, ДАА) 2023 оны I улирлын ажлын тайлан, зардлын гүйцэтгэл, II-IV улирлын төлөвлөгөө	Хэлэлцэж, баталсан
	ДАГ-ын хэлтсийн захирлыг томилох санал	Хэлэлцэж, дэмжсэн

ТУЗ-ийн Хараат бус гишүүний хувьд дараах зүйлсийг онцолсон. Үүнд:

- Голомт банкны 2023 оны 5 дугаар сарын санхүүгийн үр дүнг хянаж Чанаргүй зээлийн хувь өсөж байгаа шалтгааны талаар асууж, хариултаа авсан.

- PwC-ээс өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хянаж эдгээр зөвлөмжүүдийг цаг хугацаанд, чанартай биелүүлэхийг сануулсан.

- Монголбанканд хүргүүлэх Тогторжуулах төлөвлөгөөний шинэчилсэн найруулгыг хянасан.

- Дотоод аудитын газраас (ДАГ)-аас танилцуулсан аудитын тайлангуудтай дэлгэрэнгүй танилцаж, хянасан.

- Мэдээллийн системийн patch удирдлага сул байснаар ямар эрсдэл учирч болох талаар асуулт асууж, хариулт авсан.

- Дотоод аудитын үйл ажиллагаа (ДАҮА)-ны үйл ажиллагааны тайлан, зардлын гүйцэтгэл, 2023 оны 3, 4-р улирлын ажлын төлөвлөгөөтэй танилцсан ба 2023 оны 3, 4-р улирлын төлөвлөгөөг баталсан.

- А.Туяаг Дотоод аудитын газрын захирал, Б.Хишигжаргалыг ДАГ-Ерөнхий аудитын захирлаар томилох саналтай танилцаж, хянасан. CV, ололт, амжилт, банканд оруулсан хувь нэмэртэй танилцаж, саналыг дэмжсэн.

Миний бие Хараат бус гишүүнийхээ хувьд аудитын тайлан, төлөвлөгөөний тайлангийн хэрэгжилтийг сайтар судалж Аудит хариуцсан захирлын гүйцэтгэсэн онц ажлыг магтсан.

Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүний хувьд дараах байдлаар оролцсон. Үүнд:

Тус улиралд Эрсдэлийн удирдлагын хороо нь 9 удаа хуралдаж, нийт 36 асуудлыг дараах өдрүүдийн хурлаар хэлэлцсэн.

- 2023.04.05
- 2023.04.18
- 2023.04.20
- 2023.04.27
- 2023.05.21
- 2023.05.23
- 2023.05.31
- 2023.06.20
- 2023.06.26

Санхүүжилтийг батлахад нарийвчлан хянаж, санал хураалтыг цахимаар авдаг. Асуудлуудын ихэнх нь 20.0 тэрбум төгрөг ба түүнээс дээш зээлийн өрийн үлдэгдэлтэй аж ахуйн нэгжийн зээлийн өрийн үлдэгдэлтэй холбоотой Зээлийн хорооны шийдвэрийг хянан шалгах талаар байв.

Чухал хэлцэл:

Тус тайлангийн хугацаанд хийгдсэн гүйлгээнүүдийн бүх холбогдох мэдээллийг хүлээн авч асуудлуудад дэмжсэн санал өгсөн.

- ТУЗ-ийн болон Хороодын хурлуудад Удирдлагууд болон гишүүд хамт оролцсон. Хэлэлцэх нь нээлттэй. ТУЗ-ийн гишүүд удирдлагын бодлого болон үр дүнгийн талаар чөлөөтэй асуулт асуух боломжтой. Шаардлагатай тохиолдолд зохих хэмжээний шүүмжлэл хийж болно.

- ТУЗ-ийн болон Хороодын хурлын өмнө гишүүдэд нарийвчилсан мэдээдэд бэлдэх асуудлыг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга хариуцдаг. Гишүүд мэдээллээр маш сайн хангагдсан байдаг бөгөөд хурлын үеэр үр дүнтэй хувь нэмэр оруулдаг.

- Банкны бүтэц зохион байгуулалт нь сайжирч буй хэвээр бөгөөд банк нь, тэр дундаа Дотоод аудитын газар, үр дүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

Цаашлаад, ТУЗ-ийн Хараат бус гишүүний хувьд дараао зүйлсийг онцолмоор байна. Үүнд:

- Миний мэдлэгийн хэмжээнд ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын шийдвэр нь Банкны эрх ашгийн төлөө, шударгаар гарахыг баталж байна.
- ТУЗ-ийн үйл ажиллагаа нь бодлого боловсруулагчдаас гаргасан хууль тогтоомжийн дагуу явагддаг.
- Ярвигтай асуудлуудад ТУЗ удирдамж өгч байсан.
- Тус тайлангийн хугацаанд, миний бие Голомт банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүний хувьд банканд сөргөөр нөлөөлөх ямарваа буруутай үйлдлийг илрүүлээгүй тул ямар нэгэн тодорхой асуудлаар тусгай хурал хийх шаардлага байгаагүй.
- ТУЗ болон Удирдлага нь гаргасан шийдвэр, түүний үндэслэлийн талаар ил тод байж, цаг тухайд нь мэдээлдэг.
- Банкны удирдлага одоогийн байдлаар үйл ажиллагааны төлөвлөгөөг биелүүлж байна.
- Миний бие шийдвэр гаргахад хангалттай мэдээллийг хүлээн авсан.

Гарын үсэг зурсан:

Александр Пикер

Монголбанканд
Голомт банкны ТУЗ-ийн хараат бус гишүүний 2023 оны II улирлын тайлан

Хараат бус гишүүн Antonio López Abelló

Миний бие Antonio López Abelló нь Голомт банкны (“Голомт” буюу “Банк”) Төлөөлөн удирдах зөвлөлийн (“ТУЗ”) хараат бус гишүүн болно.

Би дараах ТУЗ-ийн хурлууд, Эрсдэлийн хороо, Аудитын хороо болон Нэр дэвшүүлэх хорооны хурлуудад цахим хэлбэрээр оролцсон болно:

Огноо	Хурал	Хэлэлцсэн асуудал	Шийдвэр	Санал
05.04.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит/	Төв оффисийн барилга захиалан бариулах тухай	Голомт банкны Төв оффисийн барилгын ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулахыг Голомт банканд зөвшөөрсөн.	Дэмжсэн
21.04.23	Бусад	Голомт банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр нэр дэвшиж байгаатай холбоотой мэдэгдэл гаргасан	Хувийн мэдэгдэл	N/M
12.05.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	ТУЗ-ийн даргыг сонгох тухай	Голомт банкны ТУЗ-ийн даргаар Чүлтэм овогтой Мөнхцэцэгийг сонгосон.	Дэмжсэн
12.05.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	ТУЗ-ийн хорооны гишүүнчлэл: Аудитын хороо	Аудитын хорооны даргаар Ноён Жэймс Б.Двайер сонгогдсон. Хорооны гишүүдээр Ноён Антонио Л.Абэлло, Ноён Александр Пикер, Хатагтай Ч.Мөнхцэцэг, Ноён Д.Мөнхтөр нар сонгогдсон.	Дэмжсэн
		ТУЗ-ийн хорооны гишүүнчлэл: Эрсдэлийн удирдлагын хороо	Эрсдэлийн удирдлагын хорооны даргаар Ноён Жэймс Б.Двайер сонгогдсон. Ноён Антонио Л.Абэлло, Ноён Александр Пикер, Хатагтай Ч.Мөнхцэцэг, Ноён Ж.Үнэнбат нар сонгогдсон.	Дэмжсэн
		ТУЗ-ийн хорооны гишүүнчлэл: Нэр дэвшүүлэх хороо	Засаглал, ёс зүй, цалин урамшуулал, нэр дэвшүүлэх даргаар Ноён Александр Пикер сонгогдсон. Хорооны гишүүдээр Ноён Роберт В.Ван Свите болон	Дэмжсэн

			Хатагтай Ч.Мөнхцэцэг нар сонгогдсон.	
		ТУЗ-ийн хорооны гишүүнчлэл: Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хороо	Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хорооны даргаар Ноён Антонио Л.Абэлло сонгогдсон. Хорооны гишүүдээр Ноён Жэймс Б.Двайер болон Хатагтай Ч.Мөнхцэцэг нар сонгогдсон.	Дэмжсэн
12.05.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит/	ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хорооны тухай	ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, ёс зүй, цалин урамшуулал, нэр дэвшүүлэх үйл ажиллагаатай холбоотой хэсгийг салгаж Нэр дэвшүүлэх хороог шинээр байгуулсантай холбоотойгоор Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хороог өөрчлөн байгуулсан.	Дэмжсэн
19.05.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийн урамшууллын тухай	Гүйцэтгэх захирлын 4 жилийн контрактын ажлын гүйцэтгэлийг дүгнэсний үндсэн дээр урамшуулал олгох болсон.	Дэмжсэн
19.05.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	Гүйцэтгэх захирлын гэрээг сунгах тухай	Голомт банкны Гүйцэтгэх захирал Като овогтой Норихико-тай дахин нэг жилийн хугацаагаар контрактын гэрээг сунгасан.	Дэмжсэн
23.06.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	Голомт банкны “Тогтворжуулах төлөвлөгөө-2023” батлах тухай	Голомт банкны “Тогтворжуулах төлөвлөгөө-2023”-г баталсан.	Дэмжсэн
23.06.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	Голомт банкны бүтэц зохион байгуулалтыг өөрчлөн батлах тухай	Голомт банкны бүтэц зохион байгуулалтыг өөрчлөлтийг баталсан.	Дэмжсэн
23.02.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	Аудит хариуцсан захирлыг ажлаас чөлөөлөх тухай	Аудит хариуцсан захирал Амарзаяагийн Одонбаатар нь Гүйцэтгэх захирлын орлогчийн албан тушаалд томилогдсон тул Аудит хариуцсан Захирлын үүрэгт ажлаас чөлөөлсөн.	Дэмжсэн
23.06.2023	ТУЗ-ийн хурал	Голомт банкны Зээлийн хорооны дүрэм болон	Голомт банкны Зээлийн хорооны дүрэм болон	Дэмжсэн

	/ээлжит/	Эрх бүхий этгээдийн зээл шийдвэрлэх матрицийг өөрчлөн батлах тухай	Эрх бүхий этгээдийн зээл шийдвэрлэх матрицийг өөрчлөн баталсан.	
--	----------	--	---	--

2023 оны 5 сарын 25-ны өдөр Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хороо хуралдан санал хурааж Гүйцэтгэх захирлын гүйцэтгэл болон урамшуулал, Гүйцэтгэх захирлын гэрээний хугацаа сунгалт, Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хорооны дүрэм, гишүүнчлэлийг хэлэлцэн баталсан.

Хараат бус гишүүний хувьд дараах саналыг хэлсэн:

Эрсдэлийн удирдлагын хорооны даргын хувьд дараах байдлаар оролцсон. Үүнд:

Тус улиралд Эрсдэлийн удирдлагын хороо нь 9 удаа хуралдаж, нийт 36 асуудлыг дараах өдрүүдийн хурлаар хэлэлцсэн.

- 2023.04.05
- 2023.04.18
- 2023.04.20
- 2023.04.27
- 2023.05.21
- 2023.05.23
- 2023.05.31
- 2023.06.20
- 2023.06.26

Санхүүжилтийг батлахад нарийвчлан хянаж, санал хураалтыг цахимаар авдаг. Асуудлуудын ихэнх нь 20.0 тэрбум төгрөг ба түүнээс дээш зээлийн өрийн үлдэгдэлтэй аж ахуйн нэгжийн зээлийн өрийн үлдэгдэлтэй холбоотой Зээлийн хорооны шийдвэрийг хянан шалгах талаар байв.

Чухал хэлцэл:

Тус тайлангийн хугацаанд хийгдсэн гүйлгээнүүдийн бүх холбогдох мэдээллийг хүлээн авч асуудлуудад дэмжсэн санал өгсөн.

Дээр дурдсан бүх асуудлыг Голомт банкны захирлууд болон Голомт компанийн удирдлагуудтай чөлөөтэй ярилцсан гэдгийг онцлон хэлэх ёстой. ТУЗ болон түүний гишүүд миний мэдлэгийн дагуу, надад өгсөн мэдээлэлд үндэслэн Голомт банкны гол оролцогч талуудын эрх ашгийг нэн тэргүүнд тавихыг хичээсээр ирсэн.

Дээр дурдсан зүйлсээс гадна Голомт банкны ТУЗ-ийн гишүүний хувьд миний үүрэг хариуцлагын талаар дараах зүйлийг онцолж хэлмээр байна.

- Миний туршлагаас банкны аль нэг ажилтан, ТУЗ-ийн бусад гишүүд болон/эсвэл хувьцаа эзэмшигчид ашиг тусыг нь авч болох асуудлыг ТУЗ-өөс тогтоосон тохиолдолд би эдгээр асуудалд заавар, санал өгөх бүрэн эрх чөлөөтэй байсан. Үүнтэй холбогдуулан Удирдах зөвлөлийн гишүүдийн санал, хүсэлт, зөвлөмжийг удирдлагаас тогтмол авч, шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь авч ажиллаж байна.
- Тайлангийн хугацаанд Би Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд Банкинд сөргөөр нөлөөлөх аливаа буруутай үйлдлийг илрүүлээгүй. Тиймээс би ямар нэгэн тодорхой асуудлаар ээлжит бус хурал хуралдуулах шаардлага тавиагүй.
- Удирдах зөвлөл, Хорооны хуралд удирдлага болон Захирлууд хамтран оролцдог. Хэлэлцүүлэг нээлттэй байна. Удирдах зөвлөлийн гишүүд удирдлагын бодлого, үр дүнг чөлөөтэй асууж болно. Шаардлагатай бол эрүүл шүүмжлэл хийх боломжтой.
- ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь ТУЗ болон хорооны хурлын өмнө Удирдах зөвлөлийн гишүүдэд зориулсан дэлгэрэнгүй мэдээллийг бэлтгэхэд хяналт тавидаг. Захирлуудад холбогдох хуралдааны өмнө тулгамдаж буй асуудлын талаар мэдээлэл өгдөг.
- Миний мэдэхээр ТУЗ болон банкны удирдлагууд үйл ажиллагаагаа ил тод явуулж ирсэн
- Голомт нь 2023 оны 2-р улиралд ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, хөрөнгө босгох чиглэлээр амжилттай ажиллаж байна.
- 2022 оны 11 дүгээр сард Голомт банк IPO хийхтэй холбогдуулан санхүүгийн зах зээлийн тогтворгүй байдал, эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдал, Монгол Улсын институциональ хөрөнгө оруулагчдын нөөц хязгаарлагдмал байгаа нөхцөлд Голомт банкны хувьцааны үнийг хэрхэн нэмэгдүүлэх талаар ТУЗ-ийн гишүүд болон удирдлагуудын дунд хэлэлцүүлэг өрнүүлсэн.

Хүндэтгэсэн,

Antonio López Abelló
Хараат бус гишүүн

**Монголбанканд
Голомт банкны ТУЗ-ийн хараат бус гишүүний 2023 оны II улирлын тайлан**

Хараат бус гишүүн Robert W. van Zwieten

Миний бие, Robert W. van Zwieten, 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Голоомт банкны (“Голомт” буюу “Банк”) Төлөөлөн удирдах зөвлөлийн (“ТУЗ”) хараат бус гишүүнээр томилогдон Монголбанкнаас холбогдох зөвшөөрлийг авсан. Мөн Нэр дэвшүүлэх хорооны даргаар томилогдсон.

Би 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрөөс 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хорооны бүх хуралд цахим хэлбэрээр оролцсон.

Он сар өдөр	Хурал	Хэлэлцсэн асуудал	Шийдвэр	Санал
12.05.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	ТУЗ-ийн даргыг сонгох тухай	Голомт банкны ТУЗ-ийн даргаар Чүлтэм овогтой Мөнхцэцэгийг сонгосон.	Ажиглагч
12.05.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	ТУЗ-ийн хорооны гишүүнчлэл: Аудитын хороо	Аудитын хорооны даргаар Ноён Жэймс Б.Двайер сонгогдсон. Хорооны гишүүдээр Ноён Антонио Л.Абэлло, Ноён Александр Пикер, Хатагтай Ч.Мөнхцэцэг, Ноён Д.Мөнхтөр нар сонгогдсон.	Ажиглагч
		ТУЗ-ийн хорооны гишүүнчлэл: Эрсдэлийн удирдлагын хороо	Эрсдэлийн удирдлагын хорооны даргаар Ноён Жэймс Б.Двайер сонгогдсон. Ноён Антонио Л.Абэлло, Ноён Александр Пикер, Хатагтай Ч.Мөнхцэцэг, Ноён Ж.Үнэнбат нар сонгогдсон.	Ажиглагч
		ТУЗ-ийн хорооны гишүүнчлэл: Нэр дэвшүүлэх хороо	Засаглал, ёс зүй, цалин урамшуулал, нэр дэвшүүлэх даргаар Ноён Александр Пикер сонгогдсон. Хорооны гишүүдээр Ноён Роберт В.Ван Свите болон Хатагтай Ч.Мөнхцэцэг нар сонгогдсон.	Ажиглагч

		ТУЗ-ийн хорооны гишүүнчлэл: Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хороо	Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хорооны даргаар Ноён Антонио Л.Абэлло сонгогдсон. Хорооны гишүүдээр Ноён Жэймс Б.Двайер болон Хатагтай Ч.Мөнхцэцэг нар сонгогдсон.	Ажиглагч
19.05.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийн урамшууллын тухай	Гүйцэтгэх захирлын 4 жилийн контрактын ажлын гүйцэтгэлийг дүгнэсний үндсэн дээр урамшуулал олгох болсон.	Дэмжсэн
19.05.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	Гүйцэтгэх захирлын гэрээг сунгах тухай	Голомт банкны Гүйцэтгэх захирал Като овогтой Норихико-тай дахин нэг жилийн хугацаагаар контрактын гэрээг сунгасан.	Дэмжсэн
28.06.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	Голомт банкны “Тогтворжуулах төлөвлөгөө-2023” батлах тухай	Голомт банкны “Тогтворжуулах төлөвлөгөө-2023”-г баталсан.	Дэмжсэн
28.06.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	Голомт банкны бүтэц зохион байгуулалтыг өөрчлөн батлах тухай	Голомт банкны бүтэц зохион байгуулалтыг өөрчлөлтийг баталсан.	Дэмжсэн
28.02.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит бус/	Аудит хариуцсан захирлыг ажлаас чөлөөлөх тухай	Аудит хариуцсан захирал Амарзаяагийн Одонбаатар нь Гүйцэтгэх захирлын орлогчийн албан тушаалд томилогдсон тул Аудит хариуцсан Захирлын үүрэгт ажлаас чөлөөлсөн.	Дэмжсэн
03.07.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит/	Голомт банкны Зээлийн хорооны дүрэм болон Эрх бүхий этгээдийн зээл шийдвэрлэх матрицийг өөрчлөн батлах тухай	Голомт банкны Зээлийн хорооны дүрэм болон Эрх бүхий этгээдийн зээл шийдвэрлэх матрицийг өөрчлөн баталсан.	Дэмжсэн

Намайг элссэнээс хойш Нэр дэвшүүлэх хороо нь 2023 оны 6 дугаар сарын 27-ны өдөр нэг удаа хуралдаж, энэ хурлаар нэг асуудал хэлэлцсэн.

Огноо	Хэлэлцсэн асуудал	Санал
27.06.2023	А.Одонбаатарыг Гүйцэтгэх захирлын орлогчоор томилж, энэхүү	Дэмжсэн

	томилгоотой холбоотой банкны бүтцэд өөрчлөлт оруулах.	
--	---	--

ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд би дараахь зүйлийг онцлон тэмдэглэхийг хүсч байна:

- Миний мэдэж байгаагаар Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагын шийдвэрүүд нь зөвхөн банкны эрх ашгийн төлөө, өөр бусад ашиг сонирхолгүйгээр гардаг гэдгийг баталж байна.

- ТУЗ-ийн үйл ажиллагаа нь бодлого боловсруулагчдаас гаргасан хууль тогтоомжийн дагуу явагддаг.

- ТУЗ-өөс засч сайжруулах боломжтой асуудлыг олж харсан тохиолдолд бид ТУЗ-ийн түвшинд хэлэлцүүлж, үйл ажиллагааг сайжруулах чиглэл өгч, эргэн мэдээлэх хугацаа өгсөн. Гүйцэтгэх удирдлагын баг эдгээр хүсэлтийг хүлээн авч, шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь авч ажиллаж байна.

- Би тайлант хугацаанд тус банкны ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд банкинд сөргөөр нөлөөлөх ямар нэгэн буруутай үйлдлийг илрүүлээгүй. Тиймээс би ямар нэгэн тодорхой асуудлаар ээлжит бус хурал хуралдуулах хүсэлт гаргаагүй.

- ТУЗ болон Удирдлагын баг нь гаргасан шийдвэр, үндэслэлийн талаар ил тод байж, цаг тухайд нь ил тод мэдээлдэг.

- ТУЗ-өөс тайлант хугацаанд гаргасан бүх шийдвэрийг санал хураалтад миний зүгээс маш сайн судалж, дэмжсэн болохыг үүгээр баталж байна.

- Надад асуулт эсвэл нэмэлт тодруулга авах шаардлага үүссэн тохиолдолд ТУЗ болон Удирдлагын багийн гишүүд зохих мэдээллийг өгч, хамтарч ажилладаг.

- ТУЗ, Хорооны хуралд удирдлагын баг болон захирлууд хамтран оролцож, нээлттэй хэлэлцүүлэг явуулдаг. ТУЗ-ийн гишүүд удирдлагын бодлого, үр дүнг чөлөөтэй асууж болно. Шаардлагатай бол эерэг шүүмжлэл хийх боломжтой.

- ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ болон хорооны хуралдааны өмнө ТУЗ-ийн гишүүдэд гишүүдэд зориулсан дэлгэрэнгүй мэдээллийг бэлтгэхэд хяналт тавьдаг. Захирлууд маш сайн мэдээлэлтэй бөгөөд уулзалтад үр дүнтэй хувь нэмэр оруулж чадна.

Хүндэтгэсэн,

Robert W. van Zwieten
Хараат бус гишүүн